



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 11 өдөр

Дугаар А/294

Хэрлэн сум

Аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст
дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван наймдугаар хуралдааны 2023 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Иргэдийн оролцоот - Хэтийн Хэнтий арга хэмжээний хүрээнд хөдөө орон нутгийн иргэдэд “Эд хөрөнгийн бүртгэлийн цогц үйлчилгээг сумдад хүргэх” ажлыг зохион байгуулахад зориулж Улсын бүртгэлийн хэлтэст 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Иргэдийн оролцоот - Хэтийн Хэнтий” арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа), гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны
дугаар сарын 11-ны өдрийн
дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Үзүүлэлт	Тоо хэмжээ	ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт төсөв
1	Шторк	3	Ш	100000	300000
2	Гарын авлага	600	Ш	1000	600000
3	Бичгийн цаас	15	Ш	20000	300000
4	Принтерийн хор	5	Ш	90000	450000
5	Шатахуун				1350000
					3000000